

2021 ЖИЛИЙН ТАЙЛАН



АГУУЛГА

- 04 ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ
- 05 ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ
- 07 2021 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

08 КОМПАНИЙН ТУХАЙ

- 08 Алсын хараа
- 08 Эрхэм зорилго
- 09 Үнэт зүйлс
- 09 Зарчим
- 10 Бидний түүх
- 12 Биржийн үйл ажиллагааны тойм
- 13 Бизнес загвар
- 14 Удирдлагын баг
- 16 Компанийн бүтэц

18 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

- 20 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүн
- 21 Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын тайлан
- 22 Байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд хийсэн ажлууд

23	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
24	Журам зохицуулалт
24	Шинэчлэгдсэн болон шинээр баталсан журмууд
25	Үйл ажиллагаанд мөрдөж буй стандартууд
26	Үндсэн үйл ажиллагаа
26	Арилжаа
27	Тооцооны үйл ажиллагаа
27	Эрсдэлийн удирдлага
29	Бүртгэл
30	Гишүүнчлэл
31	Бизнесийн үйл ажиллагаа
31	ICT Exro 2021/ UBX платформын нээлт
32	Шинэ өнгө төрх
33	Системийн хөгжүүлэлт
34	Хамтын ажиллагаа
35	Уулзалт, томилолт
36	Хүний нөөц
37	ТӨЛӨВЛӨГӨӨ
38	ГИШҮҮН ҮЦК-иуд
39	ХАМТРАН АЖИЛЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

Бирж	“Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ҮЦК	Үнэт цаасны компани
ТЕГ	Тооцооны ерөнхий гишүүн
ТШГ	Тооцооны шууд гишүүн
API	Application Programming Interface

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хамтрагч, мэргэжлийн оролцогч байгууллагууд болон биржийн гишүүд, олон нийт та бүхэнд их өөрчлөлт шинэчлэлтийг эхлүүлсэн 2021 оны үйл ажиллагааны тайлангаа хүргэж байгаадаа баяртай байна.

Хөрөнгийн зах зээлийн оролцогчдыг олон улсын стандартад нийцсэн, түргэн шуурхай, чирэгдэлгүй, найдвартай үйлчилгээгээр тасралтгүй хангах нь дэд бүтцийн байгууллагын үндсэн үүрэг билээ. Тиймээс бид үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш тасралтгүй олон улсын биржийн туршлагыг судалж, дэвшилтэт,

уян хатан систем цогцлоох, мэргэшсэн хүний нөөц бэлтгэх, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дараагийн шатанд гаргах бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх бэлтгэл ажлаа бүрэн хангаад байна.

Үүний тод илрэл болгон, бид 2021 оны 9 сард рэбрэндинг хийж, арилжаа, тооцооны платформын шинэ хувилбарыг UBХ нэртэйгээр танилцуулсан билээ. Мөн бид энгийн хувьцаа, бонд, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх арилжаалахаас гадна үнэт цаас зээлэн арилжих, фьючерс, опцион зэрэг үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжих боломжийг бүрдүүлэх зорилгоор бүртгэлийн болон шимтгэл хураамжийн журмаа шинэчлэн баталлаа.

Түүнчлэн, манай бирж дээр бүртгэлтэй үнэт цаасны арилжаанд оролцох хөрөнгө оруулагчдад олон улсын биржийн жишгээр уртасгасан цаг, маржин арилжаа хийх боломжийг олгох зорилгоор биржийн арилжааны болон бусад холбогдох журмуудад нэмэлт өөрчлөлтийг оруулж, оролцогч талууддаа танилцуулаад байна.

Улаанбаатар Үнэт Цаасны Бирж нь Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг хурдасгагч, түүчээлэгч байх зорилтыг тавьсан төдийгүй цаашлаад Монгол Улс, Улаанбаатар хотоо бүс нутгийнхаа санхүү, хөрөнгийн зах зээлийн төв болгох томоохон алсын хараатайгаар ажиллаж байна. Дэвшүүлсэн зорилтуудынхаа хүрээнд бид 2021 онд мэргэжлийн оролцогч талуудтай хамтран ажиллах олон ажлын сууриа тавьж гэрээ, санаж бичгүүдийг байгуулан ажиллалаа.

Биржийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, зах зээлд оролцогчдын хөрөнгийн зах зээлийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор судалгааны ажлуудыг эхлүүлсэн бөгөөд цаашдаа үүний хүрээнд хийгдсэн ажлуудын үр дүнг оролцогчдод танилцуулах, хамтран сургалт зохион байгуулахаар төлөвлөөд байна.

2021 онд Монгол Улс цар тахлын хүнд нөхцөл байдалтай тулгаран эдийн засгийн хувьд тогтвортой байж чадаагүй ч нийт хөрөнгийн зах зээлийн үнэлгээ түүхэн дэх хамгийн өндөр түвшинд хүрч, биржийн хувьцааны арилжаа өсөлттэй байж хөрөнгийн зах зээлд орж ирэх мөнгөний урсгал нэмэгдсэн.

Биржийн маань хувьд их хөгжлийн гараан дээрээ ирсэн гэж харж байгаа бөгөөд бидний үйл ажиллагааг үргэлж дэмжиж ирсэн эрхэм хувьцаа эзэмшигчид, мэргэжлийн оролцогчид, хамтрагч байгууллагуудда талархал илэрхийлье. Цаашид биржийн үйл ажиллагааг өргөжүүлэн тэлж та бүхний итгэлийг алдахгүйгээр хөгжил өөд хамтдаа алхах болно.

Хөгжилд Хамтдаа

Ж.Золзаяа

Гүйцэтгэх захирал

2021 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

2021.5

Стратегийн хөрөнгө оруулалт татан төвлөрүүлж, рэбрендинг хийж эхлэв.

2021.7

Бүртгэлийн хорооны журам шинэчлэн батлуулав.

2021.8

“ҮЦТХТ” ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулав.

2021.8

“Монголын арилжаа эрхлэгчдийн холбоо” ӨЗБ-ын гишүүнээр элсэв.

2021.9

Тооцооны шууд гишүүнээр “Нейшнл секюритиз ҮЦК” ХХК, “Ард секюритиз ҮЦК” ХХК нарыг элсүүлэв.

2021.9

Грэйпсити Монголиа болон Богд банктай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав.

2021.9

Digital Nation арга хэмжээний үеэр UBX платформын нээлтээ хийж, олон нийтэд танилцуулав.

2021.10

Нийт 19 арилжааны гишүүн ҮЦК-тай болов.

2021.10

Бүртгэлийн журам, Арилжааны журам, Шимтгэл хураамжийн журмуудыг тус тус шинэчлэн батлуулав.

2021.11

Арилжааны гишүүнчлэлийн журмын нэмэлт өөрчлөлтийг батлуулав.

2021.12

Улаанбаатар Үнэт Цаасны Бирж нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхлэв.

КОМПАНИЙН ТУХАЙ

Эрхэм зорилго

Хөрөнгийн зах зээлийн
тэргүүлэгч цахим бирж байх

Алсын хараа

Бүс нутгийнхаа хөрөнгийн зах
зээлийн төв болох

Үнэт зүйл

- Хурд
- Үр ашиг
- Засаглал
- Уян хатан бодлого
- Харилцагчийн нууцлал
- Мэргэжлийн ёс зүй

Зарчим

- Хүний эрх, эрхэм чанарыг дээдэлж ажиллана.
- Сайн засаглал, ил тод байдлыг байгууллагын бүх төвшинд нэвтрүүлэн ажиллана.
- Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлж ажиллана.
- Нээлттэй уян хатан бодлого баримталж, зах зээлийн мэдрэмжтэй, хурдан шуурхай ажиллахыг эрмэлзэнэ.
- Хөрөнгийн зах зээлд шинэ, олон улсын жишигт нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж, манлайлах бодлогыг мөрдөж ажиллана.
- Хууль эрх зүйн болон бизнесийн орчиндоо шаардагдаж буй өөрчлөлтүүдийг бий болгохын төлөө санаачилга гаргаж ажиллана.
- Харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцэх, найдвартай, аюулгүй, цахим систем, дэд бүтцийг нэвтрүүлэн ажиллана.
- Харилцагчийн үйлчилгээг дээд зэрэгт барих бодлогыг чандлан мөрдөнө.
- Хамгийн авьяаслаг, хүчирхэг, мэргэжлийн, үйл хэрэгтээ үнэнч хамт олныг бүрдүүлж, ёс зүйн хэм хэмжээг ямагт өндөрт тогтоон дагаж, хууль тогтоомжийг чандлан мөрдөж ажиллана.
- Нийгмийн хариуцлага өндөртэй, нийгэмд эерэг өөрчлөлтийг түүчээлэх, байгаль орчин, эх дэлхийгээ хайрлан хамгаалах чиг хандлагыг үйл ажиллагаандаа шингээж ажиллахыг эрхэмлэнэ.

Бидний түүх

“Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК (цаашид “Бирж” гэх) нь 2007 онд байгуулагдсан “МОСДАК” ХХК (цаашид “МОСДАК” гэх) -аас үүсэлтэй. Уг компанийг хөрөнгийн зах зээлийн анхны брокер, дилерүүдийн нэг болох Ж.Эрдэнэбат санаачилж, Дэлгэрхангай ҮЦК-ийн санхүүжилтээр байгуулж байв.

МОСДАК нь тухайн үеийн хууль эрх зүйн орчинд нийцүүлэн “Дилерүүдийн арилжааны төв” болох зорилготой байсан бөгөөд Олон улсын туршлага, мэдлэг, технологийн шийдлийг дотоодын зах зээлд нэвтрүүлж хөрөнгийн зах зээлд шинэ үйлчилгээ, шинэ тогтолцоо бий болгохоор ажиллаж байв. Төслийн хүрээнд гадаадын технологи нийлүүлэгч, хөрөнгийн зах зээлийн том тоглогч болох Насдак групптэй холбогдож, дотоодын зах зээлийн судалгаа, технологийн шийдлийг хамтран боловсруулсан юм.

Төслийн баг Төрийн өмчийн хорооноос 2009-2010 онуудад зарласан Монголын хөрөнгийн биржийн менежментийн хувьчлалд Насдак групптэй хамтран оролцож хамгийн өндөр үнэлгээ авч байсан боловч тухайн хувьчлал цуцлагдсан юм. Мөн 2010-2013 онуудад Хөдөө аж ахуйн биржийн ТЭЗҮ, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн төсөл, биржийн

журам, зохицуулалтыг Хүнс, хөдөө аж ахуйн яамны захиалгаар хийж гүйцэтгэсэн бөгөөд улмаар биржийн үйл ажиллагааг эхлүүлж байсан түүхтэй.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2014 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой МОСДАК-ийн хувьцаа эзэмшигчид болон бусад 3 хүнтэй хамтран “Даац Инвестмэнт” ХХК-ийг байгуулав. Улмаар Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 7 сарын 3-ны өдрийн 312 тоот тогтоолоор охин компани болох “Дилерүүдийн арилжаа төв” ХХК-ийн нэр дээр арилжаа, клирингийн тусгай зөвшөөрлийг авч үнэт цаасны арилжаа, клирингийн үйл ажиллагааг давхар эрхлэх боломжтой болжээ.

Тусгай зөвшөөрөл авсан даруй “Дилерүүдийн арилжааны төв” ХХК нэрээ “Монголын үнэт цаасны бирж” болгон өөрчилсөн бөгөөд олон нийтэд нээлттэй компани болох зорилтын бэлтгэл ажил болгож 2017 онд хаалттай хувьцаат компани болж хэлбэрээ өөрчилж, хувьцаагаа Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгүүлсэн юм.

Бирж нь 2017 онд “Анд-Энерги” ХК-ийг бүртгэж, 2018 онд “Минж Проперти” ХХК-ийн нээлттэй бондыг гаргаж байв. Мөн 2019 онд 4 хаалттай бондын төлбөр тооцоо гүйцэтгэгчээр ажилласан бөгөөд дотоодын кастодиан банкуудтай хамтран ажиллаж эхэлсэн юм.

Дээрх хугацаанд Бирж нь Насдакийн системийн бодлогын даалгаврын дагуу системээ хөгжүүлж ирсэн бөгөөд системээ шинэчлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор нэмэлт хувьцаа гаргаж стратегийн хөрөнгө оруулагчид танилцуулж байв.

Ард санхүүгийн нэгдлийн охин компани болох "АрдЭкс" ХХК нь 2021 оны 5 сард нийт хувьцааны 18.2 хувийг авахаар хувьцаа захиалгын гэрээ байгуулан ажиллаж байна. Улмаар шинэ стратегийн түншлэлийн хүрээнд шинээр удирдлагын баг бүрдүүлж, биржийн стратеги, бодлого, бизнес загвар, систем, дэд бүтцээ бүрэн шинэчилж зах зээлд шинээр танилцуулсан.

Бирж нь 2021 оны төгсгөлд "Улаанбаатар Үнэт Цаасны Бирж" болгон нэрээ өөрчилсөн бөгөөд системийн шинэчлэлийн хүрээнд хэд хэдэн ажлыг зорин хийхээр төлөвлөөд байна.



Биржийн үйл ажиллагааны тойм

“2021 онд Бирж нийт 247 удаагийн
арилжаа зохион байгуулсан бөгөөд
24,712,600 төгрөгийн үнийн дүн бүхий
хувьцаа арилжсан байна.” ”

2021 оны эцэст Бирж нийт 19 гишүүн үнэт цаасны компани, 5 тооцооны гишүүн, 2 зах зээл үүсгэгчтэйгээр үйл ажиллагаа явууллаа.


Бидний арилжаанд нэвтрүүлж буй зарчмуудын нэг нь хөрвөх чадварыг өндөр байлгах явдал юм. Тус зарчмын хүрээнд зах зээл үүсгэгчтэй үнээр удирдуулсан аргачлалыг зах зээлд нэвтрүүлж, хөгжүүлж ирсэн. 2021 онд хувьцааны талбарт нийт 24,712,600 төгрөгийн үнийн дүн бүхий 383,300 ширхэг хувьцаа арилжаалагдсан.

Бид төлбөр тооцоонд олон улсад түгээмэл хэрэглэгддэг T+2 загварыг ашиглаж байгаа бөгөөд маржин арилжааг санал болгож байна. Үүнээс гадна тооцооны үйл ажиллагааны шинэ аргачлал, шийдлүүдийг нэвтрүүлсэн.

Тухайлбал, төлбөр, тооцооны эрсдэлийг бууруулах зорилгоор үнэт цаас зээлэх, зээлдүүлэх, барьцаалах үйлчилгээг мэргэжлийн оролцогчдод санал болгож байна. Тооцооны үйл ажиллагааны хүрээнд 2021 онд өөрийн тооцооны гишүүдээр дамжуулан нийт 20,656,200 төгрөгийн төлбөр тооцоог гүйцэтгэжээ.

Бирж нь 2019 оноос хойш Биржийн бус зах зээлийн зарим төлбөр тооцоог гүйцэтгэж ирсэн бөгөөд 2021 онд биржийн бус зах зээлд нийт 6,529,948,589 төгрөгийн төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн байна.

Бизнес загвар



Үйлчилгээ

Мэргэшсэн баг хамт олон түргэн, шуурхай, мэргэжлийн үйлчилгээ



Бүтээгдэхүүн

Олон улсын жишигт нийцсэн санхүүгийн хэрэгслүүд



Систем, дэд бүтэц

Мэргэжлийн оролцогч талуудад нээлттэй, арилжаа тооцооны платформ



2 in 1

Арилжаа, тооцооны үйлчилгээ нэг дор



Уян хатан зохицуулалт

Шинээр үнэт цаас гаргах гэж буй компаниудад зориулсан уян хатан бодлого



Шинэ соёл

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг хурдасгах шинэ соёл

Удирдлагын баг



Гүйцэтгэх захирал

Ж.Золзаяа



Дэд захирал

Б.Буянхишиг



Мэдээлэл технологи хариуцсан захирал

О.Барсүрэн



Бизнес хөгжил
хариуцсан захирал

М.Даваажаргал



Зах зээлийн үйл ажиллагаа
хариуцсан захирал

Б.Баяржаргал


Удирдлагын багийн туршлага:

Биржийн удирдлагын багийн хөрөнгийн зах зээлд ажилласан нийт хугацаа 70 гаруй жил бөгөөд дотоодын зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр Насдак групп, олон улсын биржүүд, мэргэжлийн хөрөнгө оруулалтын сан, глобал кастодиан зэргээс тэргүүн туршлагуудыг судалсан. Мөн дотоодын зах зээлд Монголын

Хөрөнгийн Бирж, Монголын Үнэт Цаасны Бирж, Хөдөө аж ахуйн бирж, тэргүүлэх андеррайтерийн компани, кастодиан банк, үнэт цаасны компаниуд, хувьцаат компаниудад систем дэд бүтэц, IPO, арилжаа, дотоод процесс, ТУЗ-ийн үйл ажиллагаа, журам зохицуулалтын чиглэлээр туршлага хуримтлуулсан мэргэшсэн баг юм.



Компанийн бүтэц



Дэд Хороод



Схем 1. Компанийн бүтэц

2021 онд Бирж нь бүтцийн шинэчлэл хийж нийт 4 газар, 15 ажилтантай үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд цомхон бүтэцтэйгээр чанартай, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхээр зорьж ажиллаж байна.


КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

2021 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Бирж нийт 549.05 сая ширхэг энгийн хувьцааг эргэлтэд гаргаснаас 301.0 сая ширхэг буюу 54.12 хувийг үүсгэн байгуулагч Даац инвестмент ХХК, 30.0 сая ширхэг буюу 5.46 хувийг Даац менежмент ХХК эзэмшиж байгаа бол 100 сая ширхэг буюу 18.21 хувийг АрдЭкс ХХК, бусад 118.05 сая ширхэг буюу 22.21 хувийг 24 жижиг хувьцаа эзэмшигч хуваан эзэмшиж байна. Бирж нь зохицуулалттай этгээдийн хувьд хувь нийлүүлсэн хөрөнгө, тохиромжтой этгээдийн зөвшөөрлийг СЗХ-оос авдаг бөгөөд АрдЭкс компанийн хөрөнгө оруулалтын зөвшөөрлийг СЗХ-д хянуулахаар хүргүүлсэн.

Бирж нь Хаалттай хувьцаат компани хэлбэртэй бөгөөд Компанийн эрх барих дээд удирдлага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн чөлөөт цагт Компанийн үйл

ажиллагааг удирдан чиглүүлэх этгээд нь Төлөөлөн удирдах зөвлөл байна. Гүйцэтгэх захирал нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулдаг.

Бирж нь 2021 онд компанийн засаглалыг оролцогч тал бүрт харилцан үр ашигтай байдлаар хэрэгжүүлэхээр бизнесийн зорилтуудаа дэвшүүлж, дотоод үйл ажиллагааны хяналт, процесс, тайлагнал мэдээллийн ил тод байдалд онцгой анхаарч ажилласан. Дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд сар бүр гүйцэтгэлийг үнэлэн, Төлөөлөн удирдах зөвлөл болон хувьцаа эзэмшигчдэд тайлагнаж ажилласан. Тайлант хугацаанд бирж нь хаалттай хүрээнд нэмэлт хувьцааа гаргасан бөгөөд тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх эрхийг нийт хувьцаа эзэмшигчиддээ олгосон.



Схем 2. Компанийн засаглал, дотоод хяналтын бүтэц

2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 04 тоот тогтоолоор компанийн дүрмийн дагуу Биржийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд ердийн 6, хараат бус 3 гишүүнийг шинэчлэн сонгосон. Компанийн тухай хууль, Компанийн засаглалын үндэсний кодексийн холбогдох заалтад нийцүүлэн ТУЗ-ийн

дэргэд дараах 3 байнгын хороод байгуулагдан ажиллаж байна. Үүнд, Аудитын хороо, Хөрөнгө оруулалт, санхүү, эрсдэлийн хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо багтах ба хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийг хараат бус гишүүд бүрдүүлж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн



ТУЗ-ийн дарга
Нацагдоржийн ЦОГТ

“Өмгөөлийн Цогт энд Нандин” ХХН-ийн Партнер бөгөөд 2015 оноос хойш Улаанбаатар Үнэт Цаасны Биржийн ТУЗ-ийн дарга, гишүүнээр ажиллаж ирсэн.



ТУЗ-ийн ердийн гишүүн
Төмөрбаатарын БОЛД

“Даац Инвестмент” ХХК-ийн Гүйцэтгэх захирал



ТУЗ-ийн ердийн гишүүн
Хулдоржийн АМАР-ЭРДЭНЭ

“Маркет Девелопмент” ХХК Гүйцэтгэх захирал



ТУЗ-ийн ердийн гишүүн
Чулуунбаатрын ХАНДАА

“Ард менежмент” ХХК-ийн Гүйцэтгэх захирал



ТУЗ-ийн ердийн гишүүн
Чулууны ГАНЗОРИГ

“АрдЭкс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал



ТУЗ-ийн ердийн гишүүн
Өнөрбаянгийн АШХҮҮ

“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн Хуульч




ТУЗ-ийн хараат бус гишүүн
Батчулууны АНХБОЛД

“Мон Ит Булигар” ХК-ийн Гүйцэтгэх захирал



ТУЗ-ийн хараат бус гишүүн
Цэрэндоржийн БАТСҮХ

СЭЗИС-ийн экномиксийн тэнхимийн багш



ТУЗ-ийн хараат бус гишүүн
Одбаярын ОДСАЙХАН

“Huawei Technologies” ХХК Харилцагч хариуцсан захирал



ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Чинболдын АНУН

Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын тайлан

№	Огноо	Ирц	Батлагдсан тогтоолын тоо
1	2021.3.09	66.6%	2
2	2021.04.27	100%	2
3	2021.05.06	88.8%	3
4	2021.05.12	66.6%	2
5	2021.05.28	77.7%	3
6	2021.07.22	100%	7
7	2021.08.17	77.7%	4
8	2021.09.08	100%	1
9	2021.09.15	88.8%	5
10	2021.10.04	66.6%	3
11	2021.10.14	66.6%	6
12	2021.10.28	88.8%	2
13	2021.11.04	66.6%	1
14	2021.11.29	77.7%	2
15	2021.12.01	100%	1
16	2021.12.09	88.8%	12

Хүснэгт 1. ТУЗ-ийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо 4 удаа, Хөрөнгө оруулалт, санхүү эрсдэлийн хороо 4 удаа, Засаглал, нэрдэвшүүлэх, цалин урамшууллын хороо 4 удаа тус тус хуралдаж хариуцсан чиг үүргийнхээ хүрээнд зөвлөмж, дүгнэлтүүд гарган ажиллаа.

2021 онд Биржийн Хувьцаа эзэмшигчдийн хурал ("ХЭХ" гэх) 3 удаа хуралдаж 5 тогтоол гаргасан байна. Үүний дотор ХЭХ нь өөрийн эрх хэмжээний хүрээнд компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланд өгсөн аудитын дүгнэлтийг хэлэлцэх, ТУЗ-ийн гишүүдийг томилох, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах зэрэг асуудлуудаар шийдвэрүүдийг тус тус гарган ажилласан байна.

№	Огноо	Ирц	Батлагдсан тогтоолын тоо
1	2021.05.05	97.61%	2
2	2021.05.20	77.94%	2
3	2021.11.04	87.7%	1

Хүснэгт 2. Хувьцаа эзэмшигчдийн хурал

Байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд хийсэн ажлууд

Тогтвортой хөрөнгийн биржүүдийн санаачлага (SSE) гишүүн

Бирж нь 2020 онд НҮБ-тай хамтран үйл ажиллагаа явуулдаг, олон улсын 111 биржүүд гишүүнээр нэгдсэн "Sustainable Stock Exchange Initiative" – ийн гишүүн болсон.

2021 онд тус байгууллагаас зарласан жендерийн эрх тэгш байдлын зөвлөл нэртэй хөрөнгийн биржүүд болон санхүүгийн байгууллагуудаас бүрдэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд сонгогдон орж ажилласан. Ажлын хэсгийн зорилго нь жендерийн эрх тэгш байдлыг хангахад хөрөнгийн биржүүд ямар саналтай байгааг сонсох, үүнээсээ практикт суурилсан удирдамжийг боловсруулан,

мөрдүүлэх байв. Тус зорилгын хүрээнд биржийн зүгээс санал санаачлагыг дэвшүүлэн хүний нөөцийн бодлогодоо жендерийн эрх тэгш байдлыг хангах зорилт дэвшүүлэн ажиллаж байна.



Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагын хувьд Монголдоо "Тогтвортой хөгжлийн бодлогоор" тэргүүлэх, манлайлах бодлого баримтлан SSE-ийн шилдэг жишгүүдийг хэрэгжүүлэх зорилт тавин 2021 онд судалгаа хийж, 2022 оноос дараах зорилтууд дээр төвлөрөн ажиллахаар төлөвлөөд байна. Үүнд:



Мөн бид тогтвортой санхүүжилт болон ногоон санхүүжилтийн чиглэлээр Санхүүгийн зохицуулах хорооны гаргасан бодлого чиглэлийг дэмжин,

хамтран ажиллахаас гадна Биржийн компанийн засаглал, нийгмийн хариуцлагын удирдамжийг гаргахаар бэлтгэл ажлыг хангаад байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Журам, зохицуулалт

Шинэчлэгдсэн болон шинээр баталсан журмууд

Бирж нь арилжаа зохион байгуулах, арилжааны тооцооны үйл ажиллагаа хийж гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаандаа тодорхой дүрэм журмуудыг баталж мөрдүүлэх шаардлагатай байдаг. 2021 онд Санхүүгийн зохицуулах хорооноос бодлогын томоохон шинэчлэлүүдийг хийж дүрэм,

- Бүртгэлийн журам
- Шимтгэл хураамжийн журам
- Арилжааны журам

Бирж үндсэн үйл ажиллагааны журмуудаа боловсруулахад Биржийн гишүүдээс ирүүлсэн санал, хүсэлтийг тусган Санхүүгийн зохицуулах хороогоор батламжлуулсан.

Бүртгэлийн журмаар бүртгэлийн шалгуур, талбарын ангиллыг илүү тодорхой болгосноос гадна Хорооны холбогдох журмын өөрчлөлтийн дагуу зарим үнэт цаасыг хялбаршуулсан хэлбэрээр бүртгэх боломжийг бүрдүүлсэн. Тус журам батлагдсанаар илүү олон аж ахуй нэгжүүд Монголын хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах, Монгол улсын ногоон таксономид заасан үйл ажиллагааг эрхлэгчдийн ногоон бондыг хөнгөлөлттэй нөхцөлөөр бүртгэх, хөрөнгө оруулагчид олон улсын жишгээр арилжаанд оролцох зэрэг нөхцөлүүд бүрдэж,

журамдаа өөрчлөлт оруулсантай холбоотой, мөн Биржийн үйл ажиллагааг илүү хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар зах зээлд оролцогчдод хүргэх зорилгоор дараах журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулж, батламжлууллаа. Үүнд:

- Арилжааны гишүүнчлэлийн журам
- Бүртгэлийн хорооны журам

хөрөнгийн зах зээлийн хөгжлийг хурдасгах юм.

Түүнчлэн, Арилжааны журам шинэчлэгдсэнээр Монголд анх удаа хамгийн уртасгасан цагаар буюу 09:00 – 16:00 цагийн хооронд хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн арилжих боломжийг зах зээлд оролцогчдод санал болгож эхэлсэн. Үр дүнд нь, хөрөнгийн зах зээлд оролцогчид хувьцаа, бонд, хөрөнгө оруулалтын сан зэрэг санхүүгийн хэрэгслийг ажлын өдрийн турш арилжиж болохоос гадна Биржийн шинээр санал болгож буй үнэт цаас зээлэн арилжих (шорт селл), маржин арилжаа хийх боломжтой болсон. Харин шинээр баталсан шимтгэл, хураамжийн журам нь хөрөнгийн зах зээлд оролцогч бүхий л талуудад таатай, уян хатан нөхцлийг бий болгож буйгаараа давуу талтай.

Арилжааны гишүүнчлэлийн журмаар гишүүнчлэлийн шалгуур, шаардлага дахин тодорхойлсноос гадна арилжааны гишүүдэд үзүүлэх үйлчилгээг түргэн шуурхай байлгах

үүднээс өдөр тутамдаа гишүүдтэйгэрээ байгуулах эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс Гүйцэтгэх захиралд олгосон.

Үйл ажиллагаанд мөрдөж буй стандартууд

Бид дараах олон улсын мэдээллийн аюулгүй байдлын стандартуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхлээд байна. Үүнд:

- **MNS/ISO 27001: 2021 Мэдээллийн аюулгүй байдлын стандарт**
- **MNS 5969 : 2009 Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага**
- **MNS ISO 27002 : 2006 Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын үйл ажиллагааны дүрэм**



Түүнчлэн олон улсын BIS болон IOSCO байгууллагуудаас баталсан Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмуудын дагуу клирингийн (үнэт цаасны тооцооны) үйлчилгээг үзүүлж байна.

Үндсэн үйл ажиллагаа

Арилжаа

Тайлант хугацаанд анхдагч зах зээлд хувьцаа болон бондын арилжаа явагдаагүй бөгөөд хоёрдогч зах зээлд 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 247 өдрийн арилжаа явагдаж, 383,300 ширхэг, 24,712,600 төгрөгийн үнийн дүнтэй хувьцааны арилжаа явагдсан байна. 2021 онд “Анд Энерги” ХК-ийн AND хувьцааны дээд ханш 85 төгрөг, доод ханш 35 төгрөг, дундаж үнэ 64.47 төгрөг, 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хаалтын ханш 50 төгрөг байлаа.

2021 оны хамгийн өндөр дүнтэй арилжаа явагдсан сар нь 11 дүгээр сар бөгөөд нийт 20,243,200 төгрөгийн үнийн дүнтэй арилжаа явагдсан байна.

2021 оны арилжаанд дараах үнэт цаасны компаниуд оролцсон бөгөөд хамгийн өндөр дүн бүхий арилжааг “Ард Секюритиз ҮЦК” ХХК хийсэн бол “Бумбат-Алтай ҮЦК” ХХК болон “Булган брокер ҮЦК” ХХК-ууд удаалжээ.

№	ҮЦК-ийн нэр	Арилжааны дүн /төгрөг/
1	“Ард Секюритиз ҮЦК” ХХК	23,311,700
2	“Бумбат-Алтай ҮЦК” ХХК	17,174,100
3	“Булган брокер ҮЦК” ХХК	5,309,800
4	“Голомт Капитал ҮЦК” ХХК	1,229,100
5	“Дэлгэрхангай Секюритиз” ХХК	1,280,000
6	“Зэргэд ҮЦК” ХХК	169,700
7	“Мон сек” ХХК	950,800

Хүснэгт 3. Хувьцааны хоёрдогч зах зээлд оролцсон үнэт цаасны компаниудын идэвх

Арилжааны бодит цагийн болон арилжааны дараах өдөр тутмын мэдээллийг бид www.ubx.mn цахим хаягаар дамжуулан олон нийтэд тогтмол хүргэж байна. Мөн дотоод мэдээлэл эзэмшигчид болон арилжаанд оролцогч бусад этгээдүүд зах

зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх үүднээс үнэт цаасны компаниуд болон үнэт цаас гаргагчтай хамтран арилжааны хяналтыг гүйцэтгэж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01

дүгээр сарын 09-ний өдрийн 04 тоот тогтоолоор баталсан “Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам”-ын 2 дугаар бүлгийн 2.1 дэх заалтын дагуу 2021 оны арилжааны мэдээг долоо хоног, сар, улирлаар бэлтгэн СЗХ-д тогтмол хүргүүлэн ажиллаж байна. Эдгээр мэдээнд арилжааны статистик мэдээлэл, үнэт цаасны өсөлт бууралт,

зах зээлийн үнэлгээний мэдээллээс гадна арилжааны шимтгэл, үнэт цаас гаргагчтай холбоотой ногдол ашиг, үнэт цаасны компаниудын зохицуулалттай этгээдийн үйлчилгээний хөлсний мэдээллийг тусган цахимаар болон цаасаар хүргүүлдэг.

Тооцооны үйл ажиллагаа

Улаанбаатар Үнэт Цаасны Бирж ХК нь 2021 онд биржээр арилжаалсан үнэт цаасны төлбөр тооцоог хийж гүйцэтгэхээс гадна 2019 оноос өмнө төлбөр тооцоо хийлгэхээр бүртгэгдэн, биржийн бус зах зээлд арилжаалсан бондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн. Биржийн зах зээлд арилжаалсан хувьцааны нийт 292 хэлцлийн 20,656,200 төгрөг үнийн дүн бүхий төлбөрийн,

биржийн бус зах зээлд арилжаалсан бондын 6,529,948,589 төгрөг үнийн дүн бүхий эргэн төлөлтийн тооцооны үйл ажиллагааг 2021 онд хийж гүйцэтгэв.

Биржээр арилжаалсан үнэт цаасны төлбөр тооцооны үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд дэлгэрэнгүй харууллаа.


Тооцооны гишүүн	Тооцооны гишүүний төрөл	Үнэт цаасны тикер	Тооцооны дүн /төгрөг/
Нэрэн клиринг ХХК	ТЕГ	AND	6,174,600
Харз трейд ББСБ	ТЕГ	AND	1,229,100
Ард Секюритиз ҮЦК	ТШГ	AND	20,656,200
Бумбат-Алтай ҮЦК	ТШГ	AND	13,252,500

Хүснэгт 4. Биржийн хэлцэл /эмхэтгэсэн дүнгээр/

Эрсдэлийн удирдлага

Бирж нь эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг 3 түвшинд хэрэгжүүлдэг бөгөөд Биржийн мэргэжилтэн бүр хяналтын тогтолцоог

хэрэгжүүлэх үүрэгтэй ажиллана. Биржийн эрсдэлийн удирдлага дараах бүтцийн дагуу хэрэгждэг.



Схем 3. Биржийн эрсдэлийн удирдлагын бүтэц

Арилжааны эрсдэлийн удирдлага

Дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэхийн тулд биржийн арилжааны систем нь дотоод мэдээлэл эзэмшигчдийг бүртгэж, дотоод мэдээлэл эзэмшигчийн дансаар хийгдсэн

захиалга болон хэлцлийн жагсаалтыг биржийн арилжааны дансаар салгаж харуулдаг. Үүний үр дүнд хяналт, шалгалтыг бодит цагийн горимоор болон арилжааны дараа хийх боломжтой болсон.

Тооцооны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Бирж нь 2021 онд тооцооны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хүрээнд тооцооны гишүүдээс журамд заасны дагуу барьцаа, дэнчин шаардаж, доод үлдэгдлийг заасан хэмжээнд тогтмолхангуулж ажиллалаа. Арилжаанд оролцож буй оролцогчдын байршуулах дэнчингийн хувь хэмжээг 25 хувиас доошгүй байхаар, барьцаа

хөрөнгийн доод үлдэгдлийг тогтмол дүнгээр Тооцооны ерөнхий гишүүд 10,000,000 төгрөг, Тооцооны шууд гишүүд 2,000,000 төгрөг байхаар тогтоосон. Түүнчлэн 2021 онд тооцооны гишүүд төлбөрийн чадварын эрсдэлд орсон тохиолдол гараагүй бөгөөд төлбөр хугацаандаа төлөгдөөгүй, хоцорсон зэрэг асуудал үүсээгүй.

Бүртгэл

Бид энэ онд Биржийн "Бүртгэлийн журам"-ыг шинэчлэн СЗХ-оор батламжлууллаа. Тус журмыг СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д нийцүүлэн, олон улсад ашиглагддаг бүртгэлийн үйл явц, аргуудыг судлан бүртгэлийн арга хэлбэр болон тавигдах шаардлага болон түүнээс хөнгөлөгдөх чөлөөлөгдөх нөхцөлийг сайжруулах, бүртгэх үнэт цаасны нэр төрлөө нэмэгдүүлэх, хувьцаа болон бондын бүлгүүдийг нэгтгэж давхцыг арилгахад голчлон анхаарч ажилласан. Тус журмыг дагалдан батлагдах бусад журам, баримт бичгүүдийг шинэчлэхээр ажиллаж байна.

Бирж нь бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, материал, ТУЗ-ийн хурлын зар, материалыг хүлээн авч, шаардлагатай тохиолдолд үнэт цаас гаргагчдаас бусад мэдээллээ ирүүлэхийг шаардаж ажилласан. Биржийн систем, журмуудын шинэчлэлтэй

холбоотойгоор хэрэгцээт мэдээллийг бүртгэлтэй үнэт цаас гаргагчдад тухай бүр хүргэж ажиллаж байна.

Бирж бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх үүднээс Бүртгэлийн хороо болон Нийцүүлэгчийг бүртгэлийн үйл ажиллагаанд оролцуулдаг. Биржийн Бүртгэлийн хорооны 19 гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан бүртгэлийн хорооны гишүүнд нэр дэвшигчдийг нээлттэй сонгон шалгаруулах зар тавьж, нэр дэвшигчдийг бүртгэх ажлыг 2021 онд зохион байгууллаа. 2021 оны жилийн эцсийн байдлаар Бүртгэлийн хороонд нийт 12 гишүүнтэй байна. Эдгээр гишүүд нь ажиллаж буй салбартаа 5-аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн болон ёс зүйн хариуцлагатай, хараат бус гишүүд байна.



2021 оны 10 сарын 26, Бүртгэлийн хорооны гишүүдийн уулзалт

Биржийн бүртгэлийн шаардлагын дагуу бирж дээр бүртгэгдсэн II болон III ангиллалын компаниуд нийцүүлэгчээр дамжуулан зах зээлд тогтмол мэдээ гаргадаг нь бидний давуу талын нэг юм. Нийцүүлэгчид нь СЗХ-оос Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө эсвэл аудитын үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авсан хуулийн этгээд байдаг. Хуулийн болон санхүүгийн нийцүүлэгчдийн жагсаалт шинэчлэх ажлын хүрээнд нийт 12 санхүүгийн, 17 хуулийн нийцүүлэгчдийг тус тус бүртгэлээ. Бирж нь нийцүүлэгч болон үнэт цаас гаргагчийн хооронд байгуулах “Нийцүүлэх үйлчилгээний гэрээ”-нд хяналт тавих үүднээс гуравдагч тал болон гэрээ байгуулах гэрээний загварыг боловсруулсан.

“Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, СЗХ-ны “Үнэт цаасны бүртгэлийн журам” зэрэг үнэт цаасны зах зээлийн эрх зүйн орчинд гарч буй өөрчлөлтүүдтэй холбоотойгоор банк болон

Гишүүнчлэл

Бирж нь 2021 оны жилийн эцсийн байдлаар 19 арилжааны гишүүн, 3 тооцооны шууд гишүүн, 2 тооцооны ерөнхий гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант хугацаанд 2 үнэт цаасны компани Арилжааны гишүүнээр элсэж, 2 арилжааны гишүүн Тооцооны шууд гишүүний гэрээ байгууллаа.

2021 онд Биржийн гишүүдэд шинэчлэгдсэн болон шинээр батлагдсан журмын танилцуулгыг цахим

санхүүгийн зах зээлийн оролцогчдын хамтарсан уулзалтуудад мөн идэвхтэй оролцсон. СЗХ болон бусад эрх бүхий байгууллагуудын холбогдох хууль, журмын төсөлтэй танилцан тухай бүр санал хүргүүлж ажилласан.

Зохицуулах байгууллагад илгээх бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээг холбогдох маягтын дагуу тухай бүр, хугацаанд нь илгээсэн.

Бирж үнэт цаас гаргагчид зөвлөгөө өгөх үүргийнхээ хүрээнд Бүртгэлийн журам шинэчлэгдэн, батлагдсанаас хойш шинээр үнэт цаас гаргах зорилготой хэд хэдэн компанитай уулзалт зохион байгуулсан. Мөн Биржид үнэт цаас бүртгүүлэх сонирхолтой компаниудад бүртгэлийн шалгуур, үе шат, баримт бичгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл бүхий танилцуулга илгээж ажиллалаа.

уулзалтаар дамжуулан хүргэж, журмын нэмэлт, өөрчлөлтүүдэд гишүүдийн саналыг авч тусгасан.

Түүнчлэн Биржийн ТУЗ-ийн 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 39/21 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан “Арилжааны гишүүнчлэлийн журам”-ыг СЗХ-ны даргын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 349 тоот тушаалаар батламжлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ICT Экспо 2021/ UBX платформын нээлт

2021 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр ICT экспо буюу Digital Nation арга хэмжээний үеэр UBX платформын нээлтийн үйл ажиллагааг Хөрөнгийн зах зээлийн 30 жилийн ойгоор зохион байгуулсан. Нээлтийн үйл ажиллагаанд хүндэт зочид, хөрөнгө оруулагчид, ТУЗ-ийн гишүүд, хамтран ажиллагч байгууллагууд, Банкууд, Үнэт цаасны компаниуд, мэргэжлийн оролцогчид урилгаар хүрэлцэн ирж

шинэ UBX платформтой танилцлаа.

Хөрөнгийн зах зээлийн оролцогчдыг олон улсын стандартад нийцсэн, түргэн шуурхай, чирэгдэлгүй, найдвартай үйлчилгээгээр тасралтгүй хангах нь зах зээлийн дэд бүтцийн байгууллагын хувьд хамгийн чухал үүрэг билээ.




UBX платформ нь дэд бүтцийн болон бусад мэргэжлийн байгууллагуудын системтэй шууд холбогдох боломжтой уян хатан, цогц систем ба хөрөнгийн зах зээлд шинэ боломжуудыг нээж байгаагаараа онцлогтой юм.

Мөн энэ үеэр зах зээлийн хамтран зүтгэгчдээс гадна тус экспог зорин ирсэн олон нийтэд өөрсдийн шинэ платформ болон Биржийн үйл ажиллагааг таниулан сурталчлах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан.

Шинэ өнгө төрх

2021 онд Рэбрандинг хийснээр системийн хөгжүүлэлтээс гадна байгууллагын өнгө төрх, логог шинэчилсэн бөгөөд Биржийн албан ёсны вебсайтаа шинэчлэн ашиглалтад оруулаад байна.

Мөн биржийн хүндэтгэлийн цанг уламжлалт хээ угалз, бэлгэ тэмдгийг шингээн урлууллаа.



Шинэчилсэн вебсайт www.ubx.mn



Шинэ лого



Биржийн цангийн бэлгэдлийн тухайд, дээд хэсэг нь "Мөнх" орон зайг оршоон баригч бөгөөд наран эхлэлийн зураг юм. Дэлхий дээр оршигч бүхэн эндээс тэтгэгдэн тэжээгддэг. Хөлний хэсэг "Гол" бөгөөд өнгөрсөн, одоо ирээдүйг бэлгэдэж халдашгүй бат бөх байх санааг агуулдаг. Цангийн тухайд, хөвөөгөөр нь төр улсын бэлгэдэл хээ хөвөрсөн, энэ нь төр улсын бэлгэдэл бөгөөд голын ланз нь өсөн дэвжих, хурдтай байхын бэлгэдэл бүхий Монгол утга агуулгыг гүн шингээсэн цан юм.


Системийн хөгжүүлэлт

Биржийн систем нь өндөр хөгжсөн хөрөнгийн зах зээлийн биржүүдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн НАСДАК-ийн бодлогын даалгаврын дагуу дотоодын хөгжүүлэгч нарын бүтээсэн арилжааны платформ юм. Манай платформ нь арилжаа, арилжааны хяналтын систем, клирингийн систем болон мэргэжлийн оролцогчдын системээс бүрдэх бөгөөд Үнэт цаасны компани, Банк, Кастодиан, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, хэвлэл мэдээллийн компани зэрэг дэд бүтцийн болон мэргэжлийн байгууллагуудтай нээлттэй API-аар холбогдох боломжтой.

UBX платформын захиалга хүлээн авах хүчин чадал, тулгалт хийх хурд болон мэдээллийн аюулгүй байдал, тогтвортой, найдвартай үйл ажиллагааг хэвийн явуулахаар системийн хөгжүүлэлт, сайжруулалтуудыг өдөр тутамдаа хийж ирсэн.

UBX платформ нь зах зээлд хэд хэдэн давуу талыг мэргэжлийн оролцогчдод олгож байна. Тухайлбал: ҮЦТХТ дээр данс бүхий бүх харилцагч нар тухайн дансаа ашиглан Биржийн арилжаанд оролцох боломжтой. Мөн мэргэжлийн оролцогчдод гаргаж өгсөн API-ууд нь Үнэт цаасны компаниудын үйл ажиллагааг цахимжуулах, тэдгээрийн зардлыг бууруулах боломж олгохоос гадна маржин арилжаа, short sell арилжаа, болон бусад шинэ бүтээгдэхүүнийг аливаа нэмэлт зардалгүйгээр хийх технологийн шийдлийг агуулсан болно.

Энэ онд бид ҮЦТХТ-тэй үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог тасралтгүй найдвартай хийх зорилгоор гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Мөн Ард секюритиз ҮЦК-ийн системийг биржийн системд холбож, амжилттай туршсаны үр дүнд харилцагчид “Ard app” ашиглан UBX биржийн арилжаанд шууд оролцох боломжтой болсон.



Хамтын ажиллагаа

2021 он Биржийн хувьд хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн, бататгасан жил болж өнгөрлөө. Стратегийн хөрөнгө оруулалт амжилттай татан төвлөрүүлж үйл ажиллагаагаа идэвхжүүлэн,

хамтын ажиллагаа, харилцан ойлголцлын санамж бичгүүд болон гэрээ хэлцлүүдийг хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн болон мэргэжлийн оролцогч байгууллагуудтай байгуулсан. Үүнд:



“ҮЦТХТ” ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулав.

(2021.8.02)



“МУЦАЭХ” ӨЗБ-ийн гишүүнээр элсэв.

(2021.8.17)



“Богд Банк” ХХК-тай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав.

(2021.9.18)



“Греип Сити” ХХК-тай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав.

(2021.9.19)



Голомт банктай хамтран ажиллах санамж бичиг байгуулав

(2021.12.27)

Уулзалт, томилолт

2021 оны 12 сард Биржийн бүртгэлтэй компани болох “Анд Энерги” ХК-ийн үйлдвэрээр зочлон уулзалт хийсэн.



Үүнээс гадна Эрдэнэт, Дархан хотуудад байрлан үйл ажиллагаагаа явуулж буй үндэсний үйлдвэрлэл эрхлэгч 4 байгууллагын төлөөллүүдтэй уулзаж, тэдний үйлдвэрүүдээр зочлон үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал, цаашдын хөгжил дэвшил, хамтын ажиллагааны талаар харилцан санал солилцсон.

Хүний нөөц

Бирж нь 2021 оныг үндсэн 4 ажилтантайгаар эхлүүлсэн бөгөөд 2021 оны эхний хагас жилд шинээр хөрөнгө оруулалт татан төвлөрүүлж, компанийн бодлого, удирдлагад өөрчлөлт оруулан хүний нөөцөө шинэчлэн бүрдүүлж ажилласан.

2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 15 үндсэн ажилтантайгаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллаж байна. Үйл ажиллагааны цар хүрээ, ачааллаас хамаарч батлагдсан бүтцийн хүрээнд 2022 онд 21 хүн хүртэлх орон тоотойгоор ажиллахаар төлөвлөж байна.

Нийт ажиллагсдыг эрүүл мэндийн даатгалд хамруулж, тэтгэврийн хуримтлалын данстай болгов.

Хөрөнгийн зах зээлийн чадварлаг мэргэшсэн баг хамт олон бэлтгэх, хөрөнгийн биржийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах үүднээс мэргэжилтэн бүрийг мэргэжлийн сургалтуудад хамруулан ажиллаа. 2021 онд мэргэжлийн

чиглэл болон хувь хүний хөгжлийн чиглэлээр нийт 20 сургалт зохион байгуулав. Сургалтын мэргэжлийн багш нараас гадна мэргэжилтнүүд өөрсдөө илтгэх ур чадвараа сайжруулах үүднээс бэлтгэн зохион байгуулж, олон талт ур чадвараа нэмэгдүүлсэн нь онцлог байв.

Ажилтны ур чадварыг хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, компанийн зөв зохистой соёлыг төлөвшүүлэх бодлого баримталдаг бөгөөд баг хамт олноо бүрдүүлэхдээ чадварлаг, авьяаслаг, ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг залуусыг сонгон ажиллуулдаг.

Түүнчлэн их сургуулийн төгсөх курсын оюутнуудыг дадлагажуулах, ажлын туршлага олгох зорилгоор дадлагажигч оюутны хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд залуу үеэ дэмжиж, хөрөнгийн зах зээлийн салбарт залуу, чадварлаг боловсон хүчинүүдийг бэлтгэхэд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

ТӨЛӨВЛӨГӨӨ

Дэвшүүлсэн зорилтууд

Хөрөнгийн зах зээлийн тэргүүлэгч цахим бирж байх Эрхэм зорилгын хүрээнд 2021–2023 онд дэвшүүлсэн зорилтуудад нийцүүлэн 2022 онд дараах зорилтуудыг тавиж ажиллахаар төлөвлөөд байна. Үүнд:

- Зах зээлд өрсөлдөхүйц систем, дэд бүтэцтэй байх;
- Зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэгч байх;
- Хөрөнгө оруулалт татаж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх;
- Хамтран ажилладаг мэргэжлийн байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, байгууллагуудаар дамжуулан арилжааны хэмжээг нэмэгдүүлэх;
- Маркетингийн цогц төлөвлөгөө боловсруулж, зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх;
- Хөрөнгийн зах зээлийн сургалт, мэдээллээр тэргүүлэгч байх;
- Олон улсын шаардлагад нийцсэн мэргэшсэн хүний нөөц, чадварлаг баг байх;
- Захиргаа, санхүү алдаагүй, зохион байгуулалт сайтай байх;
- Зохицуулах байгууллагуудад хүргүүлэх тайлан мэдээллийг цаг хугацаанд нь хүргүүлэх;
- Зах зээлийн үйл ажиллагаагаар тэргүүлэгч байх.

БИРЖИЙН ГИШҮҮН ҮЦК-ИУД

 СЕКЮРИТИЗ
ҮЦК

**Golomt
Capital**[®]
Delivering diversity



MONSEC



 **БУМБАТ
ДИТАЙ**
БРОКЕР ДИЛЕР,
АНДЕРРАЙТЕРИЙН
КОМПАНИ


АРГАЙ БЭСТ
БРОКЕР, ДИЛЕРИЙН КОМПАНИ

 **TDB
CAPITAL**



InvesCore

 **LIFETIME
INVESTMENT**
IT'S THE LIFETIME VALUE

Hunnu Empire
BROKER & DEALER


APEX
CAPITAL

**NAT
SEC**



 **GAULI**
INVESTMENT
SECURITIES


ТАВАН БОГА КАПИТАЛ
Боломжгоо бодит болго

Монгол хувьцаа
ҮЦК

Зэргэд
ҮЦК


DELGERHANGAI
securities

ХАМТРАН АЖИЛЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД



